



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 674

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Биокомбинат" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 4 нэрийн нийт 12,486,000 (арван хоёр сая дөрвөн зуун наян зургаан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Биокомбинат" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Цолмонд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Акталж, данснаас хассан хөрөнгийг сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
674 дугаар тогтоолын хавсралт

**"БИОКОМБИНАТ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	ЗИЛ-130, 89-80 УБА, 3219292	1992/2005	8,000,000.00
2	Чиргүүл, 72-20 ТЧ	1992/2002	2,500,000.00
3	Путик-дулаалгатай бор ногоон	1992/2000	1,500,000.00
4	Машины бүхээг /путик/	1992/2000	486,000.00
НИЙТ ДҮН			12,486,000.00
			(арван хоёр сая дөрвөн зуун наян зургаан мянган)